

- Мандал сумын "Хоршоог хөгжүүлэх сан"-аас бизнес эрхлэгчдэд 2011 оноос хойш 1 тэрбум гаруй төгрөгийн зээл олгосон байгаа бөгөөд цаашид тус сангийн зээл олголт тасралтгүй үргэлжилж бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

Хотоос хөдөө орон нутаг руу шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг дэмжин эхлүүлсэн. 2023 онд 60 өрхийн 2 орон сууцны барилга баригдаж байна. / 20+40 /. Мандал суманд нийт 54 орон сууцанд 1477 өрх амьдардаг энэ нь нийт өрхийн 20.8%-ийг эзэлж байгаа ба 60 өрх нэмж орон сууцанд орсноор энэ тоо 21.6 хувь болон нэмэгдэх юм. Цаашид дахиж 40 айлын 2 орон сууц баригдахаар газрын зөвшөөрлөө аван сууриа цутгасан байна. Мөн хараахан ажил нь эхлээгүй орон сууц барих эрх бүхий 3 газар төлөвлөгдсөн байна.

МАНДАЛ СУМАНД ШИЛЖИН ИРСНЭЭР:

Төрийн албан хаагчийн цалин Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 240 тоот тогтоолын дагуу нэмэгдсэн. Байгууллагын дотоод журмын дагуу ур чадварын урамшуулал цалинг нэмж авах боломж байдаг.

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөрийн насны хувиараа өрхийн үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих сангийн төсөл, хоршоог хөгжүүлэх сангийн төсөл хөтөлбөр зэрэг хэрэгждэг.

Мандал сум нь Сэлэнгэ аймгийнхаа бодлого шийдвэрийг мөрдлөг болгон эрүүл бүс болох зорилтын хүрээнд Мал аж ахуйн салбарт гаднаас малтай өрхийг хүлээн авахгүй зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа. Малчид эрчимжсэн Мал аж ахуйг түлхүү хөгжүүлэн ХААЯ, аймаг, сумаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг даган ажиллаж байна. Мандал суманд бизнесээ хөгжүүлэх боломж нөхцөлийг бодлогоор дэмжин ажиллана.



МАНДАЛ СУМ



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ДАВУУ ТАЛ:

1924 онд Ноён уулын хошууны анхдугаар их хурал хуралдаж Мандал сумыг байгуулсан ба 1949 онд Улаанбаатар-Наушкийг холбосон төмөр замын Зүүнхараа өртөө байгуулагдсан зэрэг нь эдүгээ Монгол Улсын хамгийн олон хүн амтай улсын тэргүүний Мандал сум буюу Зүүнхараа хотын үүсэл хөгжлийн түүхэнд тэмдэглэгдсэн он жилүүд юм.

Сэлэнгэ аймгийн 17 сумын нэг Мандал сум нь 484,3га хавтгай дөрвөлжин километр газар нутагтай Төв аймгийн Борнуур, баруун хойд талаараа Сэлэнгэ аймгийн Баянгол, хойд талаараа Дархан-Уул аймгийн Хонгор, Сэлэнгэ аймгийн Ерөө сумуудтай хиллэн оршдог. Нутаг дэвсгэрийн хувьд Хан Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт багтах бөгөөд Хараа, Итэм Чулуут, Хонги, Урам, Түнхэл, Шивэр голуудын сав газарт хамаарна.



99800707



<http://mandal.se.gov.mn/>

УБ хотоос 174 км Сэлэнгэ аймгийн төвөөс 220км Дархан-Уул аймгаас 110 километрийн зайд оршдог засмал замаар холбогдсон, сумын нутгаар олон улсын төмөр замын гол шугам дайран өнгөрдөг ба ачаа бараа тээвэрлэх бүрэн бололцоотой төмөр замын томоохон зангилаатай суурин юм.

Улаанбаатар-Дархан-Сэлэнгэ чиглэлийн төв замтай 45 км хатуу хучилттай замаар холбогдсон. Галт тэргээр УБ хотоос 4 цаг яваад ирэх боломжтой. Өдөрт 3 удаа суудлын галт тэрэг ирж очдог дэд бүтэц хөгжсөн нутаг юм.

Мандал сум нь засаг захиргааны 9 багтай. 7103 өрхийн 26877 хүн ам амьдардаг. Аймгийн нийт хүн амын 25%-ийг эзэлж байгаа ба хөдөлмөрийн насны 15,3 мянган хүн ам нь нийт хүн амын 57%-ийг эзэлж байна.

500 хүний суудал бүхий Мөнгөнхараа дуу бүжгийн чуулга, Спорт сургалтын цогцолбор заал, Хүүхэд хөгжлийн ордон, Ерөнхий боловсролын 7 сургууль 7 цэцэрлэгтэй. Мэргэжил сургалтын 1 Политехникийн коллежтой.

Эдийн засгийн томоохон хөшүүрэг банк санхүүгийн байгууллага болох ХААН банк, Худалдаа Хөгжлийн банк, Хас банк Төрийн банкттай. Үүрэн телефоны Мобиком, Юнитель, Скайтель, Жи мобайль зэрэг салбаруудтай. Олон сувгийн Юнивишн, Ддиш, Скаймедиа дахин дамжуулах станцуудтай өндөр хурдны интернэттэй.

Аж үйлдвэрийн салбарт улсдаа төдийгүй гадаад зах зээлд үйлдвэрлэл, технологи, бүтээгдэхүүнээрээ танигдсан Спирт Бал Бурмын үйлдвэр мөн Монгол Улсынхаа эдийн засгийн салбарт голлох үүргийг гүйцэтгэгч төмөр замын салбарт үнэтэй хувь нэмэр оруулж байгаа Ачааны вагон засварын депо, Мод боловсруулах үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүдтэй. Мөн сүүлийн жилүүдэд эсгий урлал, ноос ноолууран бүтээгдэхүүн, гутал, нарийн боов,

оёдлын цехүүд зэрэг салбар бүрт ЖДҮйлдвэрлэл үйлчилгээ эрчимтэй хөгжиж байна.

ХӨГЖЛИЙН БОЛОМЖ:

2020-2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу замхарилцааг сайжруулах чиглэлээр сумын төвийн доторх 15 километр замыг хатуу хучилттай зам болгон иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн. 2024 онд 5 километр замыг хатуу хучилттай зам болгон сайжруулахаар төлөвлөөд байна. Мөн сумын доторх худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийг бохирын нэгдсэн системд холбох ажил эхлээд байна. Өнгөрсөн онд 13,4 километр бохирын шугам хоолойг суурилуулсан байна. Цаашид А бүсэд байрлалтай бүх аж ахуй нэгж амины сууц бүхий айл өрх бохирын нэгдсэн шугамд холбогдох юм. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өнгөрсөн онуудад төвийн албан байгууллага аж ахуй нэгж, айл өрхийг дулааны нэгдсэн шугамд холбосноор янданг буулгаж чадсан.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлэх боломжтой, самар жимс гэх мэт байгалийн дагалтад баялаг ихтэй. Иргэн бүр ажилтай орлоготой байх боломжтой хурдацтай хөгжиж буй сум юм.

ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД:

Алсын хараа 2050 шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хотоос хөдөө орон нутаг руу шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Сул ажлын байрны зарыг сумын хөдөлмөр эрхлэлтийн албанд нэгтгэн нийтэд зарлан ажлын байраар зуучлан гурвалсан холбоогоор хамтран ажилладаг. Одоогоор төр, төсвийн байгууллага, "Бороо Гоулд" ХХК, хувийн хэвшилд нийт 31 сул ажлын байр зарлагдаад байна.

Дэд бүтцийн салбарт Мандал суманд шинээр төлөвлөж буй 25МВт дулааны цахилгаан станц барьж, дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийх төлөвлөгөөтэй байна.

Мөн Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх Улаанбаатар чиглэлийн 45,2 км, Түнхэл тосгон доторх 4 км хатуу хучилттай авто зам, сумын төвийн доторх 16,6 км авто зам барих ажил төлөвлөгөөнд багтсан байна.

